

Хууль, эрх зүйн мэдээлэл #4

2026 оны 7-р сар

Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих төсөл сонгон шалгаруулалтын журмыг шинэчлэн баталлаа

Хураангуй

Монгол Улсын Эрчим Хүчний Сайдын 2026 оны 5-р сарын 22-ний өдрийн А/116 дугаар тушаалаар Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих төсөл сонгон шалгаруулалтын журам (“**2026 оны журам**”)–ыг шинэчлэн баталлаа. Энэхүү журам батлагдсанаар Эрчим Хүчний Сайдын 2025 оны 9-р сарын 9-ний өдрийн А/217 тушаалаар батлагдсан Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих төсөл шалгаруулалтын журам (“**2025 оны журам**”) хүчингүй болсон байна.

Улмаар сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих төслийг сонгон шалгаруулах зохицуулалт шинэчлэгдэж байгаа тул энэхүү хууль, эрх зүйн мэдээллийн дугаарт тус журамд орсон гол өөрчлөлтүүдийг хураангуйлан хүргэж байна. Жишээлбэл, 2026 оны журмаар сонгон шалгаруулалтын хэлбэрийг нэмж, аукцион зохион байгуулах боломжтой болсон, нар, салхины үүсгүүрээс гадна батерей хуримтлуур хосолсон систем барих төсөл нь сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийн төслийн хүрээнд нэмэгдсэн зэрэг гол өөрчлөлт оржээ.

Гол өөрчлөлт

1. Аукцион

2026 оны журамд орсон гол өөрчлөлт нь сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийн төслийг шалгаруулахад аукционы аргаар шалгаруулж болох тухай зохицуулсан байна. Улмаар сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийн төслийг шалгаруулахад ердийн төсөл сонгон шалгаруулалт болон аукционаар дамжуулан төслийг шалгаруулах бөгөөд төсөл сонгон шалгаруулалт эсвэл аукционаар хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг Эрчим хүчний яамнаас батлахаар заажээ. 2026 оны журамд заасны дагуу аукцион гэж төслийг барьж байгуулах, цахилгаан эрчим хүч нийлүүлэх гэрээ байгуулах эрхийг өрсөлдөөнт үнийн саналын үндсэн дээр дуудлага худалдааны зарчмаар сонгон шалгаруулахыг ойлгодог. Энгийнээр хэлбэл хамгийн бага үнэ санал болгож буй этгээдийг зохих журмын дагуу сонгон шалгаруулах процесс юм. 2026 оны журмын хамгийн гол өөрчлөлт болох аукцион явуулах үйл ажиллагааны дараалал, онцлогтой дараах хүснэгтээс танилцана уу.

Холбоо барих:

Серги Кобахидзе

Партнер
Татвар, Хуулийн үйлчилгээ
sergi.kobakhidze@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Захирал
Татвар, Хуулийн үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Өмгөөллийн

ПрайсуотэрхаусКүүпэрс
Легал ХХН

Сентрал Тауэр, 6 давхар
605 тоот, Улаанбаатар
14200, Монгол улс
Утас : + 976 70009089
www.pwc.com/mn

Рагчаахүүгийн Мөнхжаргал

Ахлах менежер
Татвар, Хуулийн үйлчилгээ
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

Батзулын Амарбат

Менежер
Татвар, Хуулийн үйлчилгээ
amarbat.batzul@pwc.com

№ Аукцион зохион байгуулах дараалал**i. Нийтэд зарлах, хүсэлт хүлээн авах**

Аукцион эхлэхээс 40-өөс доошгүй өдрийн өмнө зохион байгуулагчийн цахим хуудас, эсхүл олон улсын өргөн хэрэглэгддэг хэл дээр гардаг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр аукционыг нийтэд зарлана. Зарлал нийтлэгдсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор сонирхогч этгээд холбогдох баримт бичгийг бүрдүүлж ирүүлнэ.

ii. Урилгыг нийтлэх

Хороо нь аукцион эхлэхээс 21-ээс доошгүй өдрийн өмнө аукционы урилгыг нийтэлж, төсөлтэй холбоотой зохих мэдээлэл, баримт бичгээр хангана.

iii. Оролцогчдыг бүртгэх

Аукционд 2026 оны журамд заасан ерөнхий шаардлагуудыг хангасан Монгол Улсын хуулийн этгээд, гадаад улсын хуулийн этгээд оролцож болно. Гадаад улсын хуулийн этгээдийн хувьд Монгол улсын хуулийн этгээдтэй түншлэлийн хэлбэрээр оролцож болох бол Монгол улсын хуулийн этгээд түншлэлээр болон дангаар оролцож болно.

Оролцогчид нь бүртгүүлэхийн тулд 2026 оны журамд заасан ерөнхий шаардлагыг хангасан байх бөгөөд шаардлагатай бүртгэлийн баримт бичгийг бүрдүүлэн Эрчим хүчний яамны дэргэдэх хороонд цахим шуудангаар илгээнэ. Шаардлага хангасан оролцогчдыг бүртгэлийн баримт бичгийг ирүүлснээс хойш ажлын 3 өдрийн дотор бүртгэнэ.

iv. Дэнчин төлөх

Бүртгэл баталгаажсан оролцогч зохих зааврын дагуу аукцион болох өдрөөс 1 өдрийн өмнө Диспетчерийн үндэсний төвийн дансанд дэнчин төлнө. Энэ хүрээнд дэнчин байршуулах гэрээ байгуулсан байна. Дэнчингийн хэмжээ нь нар, салхины цахилгаан станц болон батерей хуримтлуурын 1мВт тутамд 5000 ам.доллар байна. Аукционд шалгараагүй, аукцион цуцлагдсан тохиолдолд дэнчинг буцаан олгоно. Ялсан тохиолдолд гэрээний үүргийн баталгаанд тооцон шилжүүлнэ. Ялагч нь мөн цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ байгуулахаас зайлсхийсэн, авлига, ашиг сонирхлын зөрчил, тохиролцоо, үгсэн хуйвалдаан, хууль зөрчсөн үйлдэл гаргасан тохиолдолд дэнчинг буцаан олгохгүй.

v. Аукционыг явуулах

Аукционыг танхимаар эсхүл цахимаар зохион байгуулж болох бөгөөд дараах үндсэн дараалал, зарчмаар явуулна. Үүнд:

1. Оролцогч нь битүүмжилсэн үнийн саналыг аукцион эхлэхээс 1 цагийн өмнө тусгайлан бэлтгэсэн хайрцагт байршуулна.
2. Хороо нь тогтоосон огноо, цагт оролцогчдоос битүүмжлэн ирүүлсэн үнийн саналын хамгийн доод үнийг харуулж аукционыг нээнэ.
3. Аукцион нь үнийг бууруулан дуудах хэлбэрээр явагдана. Үнийн санал буурах хамгийн бага хэмжээ 0.05 ам.цент/кВт.ц байна.
4. Хороо нь сүүлийн үнийн саналыг зарласнаас хойш 5 минутын хугацаанд үнийн шинэ санал ороогүй тохиолдолд аукционыг хаагдсанд тооцож, ялагчийг хамгийн доод үнийн саналаар тогтооно.

www.pwc.com/mn

Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН бэлтгэсэн болно. Энд дурдсан мэдээлэл нь зөвхөн ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хуулийн зөвлөгөө биш юм. Аливаа үйлдэл (эс үйлдэхүй) хийжээс өмнө уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээлэлд үндэслэн хийсэн үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлага хүлээхгүй болно. © 2026 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү мэдээлэлд дурдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН-ийг илэрхийлнэ.

vi. **Аукционы үр дүнг мэдэгдэх, гэрээ байгуулах**

Аукцион зохион байгуулагдсан өдрөөс хойш ажлын 1 өдрийн дотор оролцогчдод шалгарсан эсэх талаар мэдэгдэл хүргүүлнэ. Эрх бүхий этгээд аукционы ялагчид цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ байгуулах эрхийг олгох бөгөөд аукцион зохион байгуулагдсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор энэ тухай мэдэгдэл хүргүүлнэ.

Гол өөрчлөлт (үргэлжлэл)

2. Төслийн хүрээ

2025 оны журамд сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийн төсөлд зөвхөн 6кв болон түүнээс дээш хүчдэлийн түвшинд сүлжээнд холбогдох нар, салхины үүсгүүрийг оруулж зохицуулсан байсан. Харин 2026 оны журамд нар салхины үүсгүүрт хүчдэлийг заагаагүйгээс гадна батарей хуримтлуур хосолсон системийг мөн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийн төслийн хүрээнд оруулсан байна.

3. Оролцогчдод тавигдах шаардлага

2026 оны журмын хувьд 2025 оны журмаас ялгаатай сонгон шалгаруулалтад оролцож буй этгээдэд тавигдах шаардлагыг нэмж, нарийвчлан зохицуулсан. Эдгээрээс онцолбол, авлига, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, хориг арга хэмжээ хэрэгжүүлдэггүй байх, оролцогч, түншлэлийн гишүүн, тэдгээрийн эцсийн өмчлөгч, толгой компани нь олон улсын санхүүгийн болон хөгжлийн байгууллагын эрх хасах, хориг арга хэмжээний жагсаалтад бүртгэгдээгүй байх зэрэг шалгуурыг нарийвчлан заасан байна.

4. Мэдээллийн ил тод байдал

2026 оны журамд мөн төсөл сонгон шалгаруулахтай холбоотой мэдээллийн ил тод байдлыг хангасан зохицуулалт нэмэгдсэн. Тодруулбал, шалгарсан этгээдтэй гэрээ байгуулснаас хойш ажлын 5 хоногийн дотор төслийн захиалагч нь цахим хуудсандаа төсөл сонгон шалгаруулалтын баримт бичиг, урьдчилсан үнэлгээний оролцогчийн тоо, шалгарсан оролцогчийн нэр, төсөл сонгон шалгаруулалтын шатанд санал ирүүлсэн оролцогчийн нэр, санхүүгийн саналыг үнэлсэн оролцогчийн нэр, төсөл нь шалгарсан оролцогчийн нэр, ирүүлсэн үнийн санал болон хорооны гишүүдийн тухай мэдээлэхээр заасан байна.



Бидэнтэй холбогдоорой

Та сэргээгдэх эрчим хүч болон бусад асуудлаар хууль эрх зүйн зөвлөгөө авахыг хүсвэл бидэнтэй холбоо барина уу. **Дээрх журмыг бүрэн эхээр нь харахыг хүсвэл энд дарж танилцана уу.**

www.pwc.com/mn

Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН бэлтгэсэн болно. Энд дурдсан мэдээлэл нь зөвхөн ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хуулийн зөвлөгөө биш юм. Аливаа үйлдэл (эс үйлдэхүй) хийжээс өмнө уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээлэлд үндэслэн хийсэн үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлага хүлээхгүй болно.

© 2026 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү мэдээлэлд дурдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН-ийг илэрхийлнэ.